



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Сүхбаатар аймаг дахь төрийн
аудитын газар

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

УУЛ УУРХАЙН ЯВЦЫН НӨХӨН СЭРГЭЭЛТ ХАНГАЛТГҮЙ, ШАТ ШАТНЫ
ХЯНАЛТ ҮР ДҮН МУУТАЙ БАЙНА.

АУДИТЫН НЭР: БАЙГАЛЬ ОРЧИН, УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ҮР ДҮН
АУДИТЫН КОД: СБА-2023/43-1-ШТА-ГА

Баруун-Урт 2023 он



Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn
Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn
Ахлах аудитор Г.Оюунболд

Утас: 70512127 Цахим хаяг: oyunboldg@audit.gov.mn
Аудитор Э.Алтансүх
Утас: 70512127 Цахим хаяг: altansukhe@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу. Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	4
БҮЛЭГ А. Ашигт малтмалын ашиглалтын төслийн ТЭЗҮ болон хаалтын менежментийн урьдчилсан төлөвлөгөөнд тавих шаардлагыг тодорхой болгох хэрэгцээ үүссэн байна.	5
А.1. Техник, эдийн засгийн үндэслэл болон хаалтын менежментийн урьдчилсан төлөвлөгөөнд тавигддаг зарим шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.	5
А.2. Хайгуулын төслийн “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө”-г хянуулах, батлуулах үйл явцыг цахим системээр гүйцэтгүүлэх шаардлагатай байна.	9
БҮЛЭГ Б. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт, түүнд тавих шат шатны хяналт үр дүнгүй байна.	11
Б.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдээс дүйцүүлэх арга хэмжээ болон мод тарих арга хэмжээнүүд бүрэн хэрэгжээгүй байна.	11
Б.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд шат шатны байгууллагууд хяналт тавьж байгаа боловч түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалттай холбоотой асуудал хүндрэл үүсгэж байна.	13
БҮЛЭГ В. Уурхайн хаалт ба нөхөн сэргээлтэд зориулан нөөц сан байгуулаагүй, Аймаг, сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүй, ААНОАТ-ын орон нутагт төвлөрөх 40 хувийг Сангийн яам олгоогүй байна.....	17
В.1. Уурхайн хаалт ба нөхөн сэргээлтэд зориулан нөөц сан байгуулаагүй, Аймаг, сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.....	17
В.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчд ААНОАТ-ыг тайлагнасан, харин борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, төлсөн татварыг олон нийтэд мэдээлээгүй байна.....	20
Холбогдох байгууллагын санал:	24
Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:	28
ДҮГНЭЛТ: 28	
ЗӨВЛӨМЖ: 29	
Үндэсний аудитын газраар уламжлуулан холбогдох төр захиргааны төв байгууллагуудад хүргүүлж буй санал, зөвлөмж:.....	30

Товчилсон үгийн тайлбар

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
АМГТГ	Ашигт малтмал газрын тосны газар
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОМТ	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
БОНБНУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БОХТ	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Хүснэгтийн жагсаалт

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Зарим төслийн олборлолт ба үйлдвэрийн нөөцийн харьцаа	5
Хүснэгт 2	Зарим төслийн нийт ашиг ба гадаад тээврийн хатуу хучилттай авто замын өртгийг харьцуулсан дүн шинжилгээ	6
Хүснэгт 3	Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлын 50 хувийн байршуулалт	10
Хүснэгт 4	Аймаг, сумын Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт	18
Хүснэгт 5	Нэг тонн нүүрсний борлуулалтын орлого ба зах зээлийн үнийн харьцаа	20

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл		
Аудит үндэслэл, эрх	хийх бүрэн	Монгол Улсын Ерөнхий аудиторов 2023 оны А/04 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг гүйцэтгэв.
Аудитын зорилт		“Байгаль орчин, уул уурхайн нөхөн сэргээлтийн үр дүн” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэнэ.
Аудитын хамарсан хүрээ		Аудитад ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй болон түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий АЗДТГ, БОАЖГ, сумын ЗДТГ, тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд, холбогдох бусад байгууллагыг хамруулан ТЭЗҮ, уурхайн нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөө, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, Аймаг, сумын Засаг даргатай байгуулсан гэрээ, байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулсан данс, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний жилийн тайлан, хяналт тавих үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны холбогдох төлөвлөгөө, тайлан, зөрчлийн шийдвэрлэлт, судалгаа, тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийн санхүү, татварын тайлан, түүний хэрэгжилтийг хамруулав.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт		Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100-400, 4000, 4001, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын зарчим, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам (2020 он)-ын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа		Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор Г.Даваа удирдаж, аудитын менежер М.Нарантуяа чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Г.Оюунболд, аудитор Э.Алтансүх нар 2023 оны 9 сарын 01-ний өдрөөс 11 сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд аудитыг гүйцэтгэв.

БҮЛЭГ А. Ашигт малтмалын ашиглалтын төслийн ТЭЗҮ болон хаалтын менежментийн урьдчилсан төлөвлөгөөнд тавих шаардлагыг тодорхой болгох хэрэгцээ үүссэн байна.

А.1. Техник, эдийн засгийн үндэслэл болон хаалтын менежментийн урьдчилсан төлөвлөгөөнд тавигддаг зарим шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.

А.1.1. Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгчийн ТЭЗҮ нь ордын нөөцийг бүрэн ашиглах, хатуу хучилттай авто замаар гадаад тээвэр хийх шаардлагад нийцэхгүй байна.

1.1.1.1. Сүхбаатар аймагт 2022 онд үйл ажиллагаа явуулсан ашигт малтмалын ашиглалтын 18 тусгай зөвшөөрөл эзэмшигч байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ТЭЗҮ нь холбогдох хууль, журмын шаардлагад нийцэж байгаа эсэхэд дараах 2 чиглэлээр дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

- Техник эдийн засгийн үндэслэл нь Ашигт малтмалын тухай хуулийн 35.5 дахь /Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглах үүрэг хүлээх бөгөөд зөвхөн ашиг олох зорилгоор түүнийг сорчлон ашиглахыг хориглоно./ заалттай нийцэж буй эсэх
- Мөн “Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам”-ын 2.3 дахь /Авто зам, замын байгууламжийг холбогдох стандарт, норм, норматив, техникийн баримт бичгийн дагуу хатуу хучилттай барина./ заалттай нийцэж буй эсэх

1.1.1.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ТЭЗҮ-ийг түүвэрлэн аудитад хамруулахад үйлдвэрлэлийн нөөц буюу олборлох боломжтой нөөцийн 11.0-35.4 хувийг төслийн хугацаанд олборлохоор ТЭЗҮ-д тусгасан байгаа нь Ашигт малтмалын тухай хуулийн 35.5 дахь заалттай нийцэхгүй байна. Тухайлбал 4 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн холбогдох мэдээллийг харуулав.

Хүснэгт 1. Зарим төслийн олборлолт ба үйлдвэрийн нөөцийн харьцаа

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Ашигт малтмалын нэр төрөл	ТЭЗҮ батлагдсан болон тодотгол хийлгэсэн он	Төслийн үргэжлэх хугацаа /жил/	Үйлдвэрлэлийн нөөц /сая тонн/	Төслийн хугацаанд нийт олборлох нөөцийн хэмжээ /сая тонн/	Төслийн олборлолт ба үйлдвэрийн нөөцийн харьцаа /хувиар/
1	Премиумкөөл корпораци ХХК	Хүрэн нүүрс	2019	10	136.01	15	11
2	Андын илч ХХК	Хүрэн нүүрс	2019	6	0.8793	0.8793	100
3	Бадмаараг хаш ХХК	Хүрэн нүүрс	2018	10	41.497	14.7	35.4
4	Дорнын чулуулаг ХХК	Хүрэн нүүрс	2018	10	62.788	19.445	31

Эх сурвалж: Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид

1.1.1.3. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 7-д "байгаль орчныг хамгаалах" гэдэгт байгаль орчныг бохирдохоос урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг нь алдагдуулахгүйгээр, байгалийн даацад нь тохируулан **зохистой ашиглах**, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавих ажиллагаа хамаарна гэж заасан. Тухайн нэг ордын олборлох боломжтой нөөцийг бүрэн бус ашиглах ТЭЗҮ-тэй байх нь байгаль орчныг хамгаалах шаардлагад нийцэхгүй, газрын хэвлийн баялгийг зохистой түвшинд ашиглахгүй байх сөрөг үр дагавартай байна.

1.1.1.4. Уул уурхайн бүтээгдэхүүний гадаад тээврийг хатуу хучилттай авто замаар хийх талаар холбогдох журамд тодорхой зааж өгсөн боловч ТЭЗҮ-д хайрган хучилттай авто замаар гадаад тээврийг хийхээр тусгах зөрчил нийтлэг байна. Зарим тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн төслийн хугацааны нийт ашгийг хатуу хучилттай авто зам барих төсөв өртөгтэй харьцуулж үзэхэд төслийн нийт ашиг нь 8.3 - 67.1 км хатуу хучилттай авто зам барих хэмжээнд байна. Өөрөөр хэлбэл энэ нь гадаад тээврийн замын нийт уртын 18.8-37.2 хувьтай тэнцэж байна.

Хүснэгт 2. Зарим төслийн нийт ашиг ба гадаад тээврийн хатуу хучилттай авто замын өртгийг харьцуулсан дүн шинжилгээ

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	Ашигт малтмалын нэр төрөл	Төслийн хугацааны нийт ашиг /тэрбум төгрөг/	Хатуу хучилттай 1 км автозамын өртөг /тэрбум төгрөг/	Төслийн нийт ашгаар тавих хатуу хучилттай авто замын урт /км/	ТЭЗҮ-д тусгагдсан бүтээгдэхүүн тээвэрлэх замын урт /км/	Гадаад тээврийн авто замын талаар ТЭЗҮ, БОНБНУ-д тусгасан байдал
1	Премиумкөөл корпораци ХХК	Хүрэн нүүрс	67.1	1.0	67.1	180.0	Хайрган хучилттай, ердийн зам
2	Андын илч ХХК	Хүрэн нүүрс	8.3	1.0	8.3	44.0	Хайрган хучилттай авто зам барих
3	Бадмаараг хаш ХХК	Хүрэн нүүрс	129.0	1.0	129.0	44.0	Хайрган хучилттай авто зам барих
4	Дорнын чулуулаг ХХК	Хүрэн нүүрс	866.3	1.0	866.3	200.0	Гадаад тээврийн замын төрлийг тодорхой тусгаагүй

Эх сурвалж: Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид

1.1.1.5. Хатуу хучилттай авто замаар уул уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх журмын зохицуулалт хэрэгжихгүй байгаа дээрх нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд тухайн ордын олборлох боломжтой нөөцийг бүрэн ашиглахаар ТЭЗҮ-д тусгаж өгөөгүй, богино хугацааны төсөл боловсруулж байгаа нь суурь шалтгаан болж байна. Өөрөөр хэлбэл урт хугацаанд нөөцийг бүрэн ашиглахуйц хэмжээний ТЭЗҮ-тэй байх зарчмыг баримталснаар хатуу хучилттай авто замыг барьж байгуулах өртөг нь төслийн нийт зардалд шингэх бөгөөд хөрсний эвдрэлээс урьдчилан сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөө багатай үйл ажиллагаа явуулах хариуцлагатай уул уурхай шаардлагад нийцэхээр байна.

1.1.1.6. Төслийн ТЭЗҮ болон тухайн жилийн БОМТ-ний хоорондын уялдааг авч үзэхэд дээр дурдсан 2 асуудлын “**ордын нөөцийг бүрэн ашиглах болон хатуу хучилттай авто замаар гадаад тээвэр хийх**” хүрээнд холбоо, хамааралтай байна.

Тодруулбал дээрх шаардлагуудыг ТЭЗҮ хангахгүй байгаа нь төсөл хэрэгжүүлэгчийн байгаль орчныг хамгаалах үүргийн хэрэгжилт болон БОМТ-ний үр дүнд сөргөөр нөлөөлөх үр дагавартай байна.

1.1.1.7. Ашигт малтмалын тухай хуулийн 26.2.3 дахь “хайгуулаар тогтоогдсон ашигт малтмалын нөөцийн хэмжээ, үнэлгээ нь олборлолтоос үүсэж болох экологийн хохирлыг нөхөн сэргээхэд хүрэлцэх эсэх.” заалтын хэрэгжилтийг хангаж ажиллах буюу гадаад тээврийг хатуу хучилттай авто замаар тээвэрлүүлэх шаардлагыг хангаж чадахуйц эсэхийг ТЭЗҮ-ийг хянаж, хүлээж авах шатанд үнэлэх шаардлагатай байна.

1.1.1.8. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь “Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ”-тэй уялдсан эсэхийг авч үзэхэд зарим тусгай зөвшөөрөл эзэмшигчийн БОНБНҮ-ний арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. Тодруулбал:

- Монгол жүанли ХХК-ийн БОНБНҮ-д тусгагдсан “Хаягдлын далангийн тоосжилтоос урьдчилан сэргийлэхийн тулд хаягдлын далан дээр хөвөгч бөмбөлгүүдийг байршуулах, хүдрийн овоолгын тоосжилтоос сэргийлж хамгаалалт хийх” арга хэмжээг БОМТ тусгаагүй, хэрэгжүүлээгүй.
- Цайрт минерал ХХК-ийн БОНБНҮ-д тусгагдсан “Хүдрийн овоолгын тоосжилтоос сэргийлж хаалт хийх” арга хэмжээг БОМТ-нд тусгаагүй, хэрэгжүүлээгүй.

1.1.1.9. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах дээрх төрлийн арга хэмжээнүүдийг тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн жилийн БОМТ-нд тусган хэрэгжүүлж буй эсэхэд “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх ажлын хэсэг” дүн шинжилгээ хийж, дараа жилийн БОМТ-нд тусгуулах саналыг Байгаль орчин, аялал, жуулчлалын яаманд жил бүр хүргүүлж ажиллах шаардлагатай байна.

А.1.2. Хаалтын менежментийн урьдчилсан төлөвлөгөөнд явцын буюу жил бүр хийх нөхөн сэргээлтийн ажлын тоо хэмжээ, зардлын дүнг тодорхой тусгадаггүйн улмаас явцын нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй орхигдох сөрөг үр дагавартай байна.

1.1.2.1. Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газрын нөхөн сэргээлтийг уурхайг хаах үед хийнэ гэсэн ойлголт төсөл хэрэгжүүлэгч болон ажил хариуцсан төрийн албан хаагч нарын дунд нийтлэг байна. Иймд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох эрх зүйн акт, стандартад явцын нөхөн сэргээлтийн талаар ямар зохицуулалттай байгааг авч үзэхэд дараах байдлаар зохицуулсан байна. Үүнд:

- “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам”-ын 4.1. “Уурхай, уулын болон баяжуулах, боловсруулах үйлдвэрийн

явцын болон хаалтын нөхөн сэргээлтийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 9.4-д заасан журам, аргачлал болон холбогдох бусад хууль, журам, стандартын дагуу төлөвлөж, хаалтын менежментийн төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэлийг хангана.”

- “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын 8.9 дэх заалт “Уурхайн ашиглалтын явцад хэрэгжүүлэх **жил бүрийн нөхөн сэргээлтийн** ажлын төлөвлөлтийг хаалтын үйл ажиллагаатай нягт уялдуулан гүйцэтгэх;”
- “Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” MNS 5917:2008 стандарт: уурхайн дүүргэлтэд ашиглахгүй, дахин боловсруулалтад орохгүй гадаад овоолгыг 25 градусын налуу үүсгэн хэлбэршүүлж, явцын техникийн нөхөн сэргээлт хийх зэрэг зохицуулалттай байна.

1.1.2.2. Эдгээрийг нэгтэн авч үзвэл явцын нөхөн сэргээлтийг хийх нь тодорхой бөгөөд энэ нь хаалтын үйл ажиллагаатай нягт уялдаа, холбоотой хэрэгжихээр байна. Мөн хаалтын менежментийн төлөвлөгөөг уурхай хаагдахаас 1-3 жилийн өмнө хийнэ гэсэн ойлголт уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч болон хяналт тавих чиг үүрэг хэрэгжүүлдэг төрийн албан хаагч нарын дунд нийтлэг байна. Иймд хаалтын менежментийн төлөвлөгөөг хэзээ боловсруулж, батлуулах, хууль тогтоомжид хэрхэн зохицуулсныг авч үзэхэд дараах зохицуулалттай байна.

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14.1.3. /газрын тос болон уул уурхайн төслүүд нь нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөөг тухайн үйл ажиллагаа эхэлж, хаалт хийхээс гурван жилээс доошгүй хугацааны **өмнө** боловсруулж, тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх./
- Ашигт малтмалын тухай хуулийн 45.1./Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хаах бол төрийн захиргааны төв байгууллагад нэгээс доошгүй жилийн **өмнө** мэдэгдэж, энэ хуулийн 10.1.14-д заасан журмын дагуу зохих бэлтгэлийг хангаж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:/
- “Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал”-ын 8-р зүйлд /Уул уурхайн төслийг хэрэгжүүлж эхлэхийн өмнө буюу техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах үе шатаас эхлэн уурхайн хаалтын менежментийг төлөвлөх шаардлагатай. Уул уурхайн үйл ажиллагаа эхлэхийн **өмнө** ТЭЗҮ боловсруулах үе шатнаас “Уурхайн хаалтын менежментийн төлөвлөгөө”-г боловсруулах/ гэж тус тус заасан байна.

1.1.2.3. Түүнчлэн Ашигт малтмалын тухай хуулийн 27.1.12-д “энэ хуулийн 48.6.1-д заасан тухайн ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлдээ тухайн уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, дэд бүтцийг хэрхэн бүрдүүлэх болон уурхайн нөхөн

сэргээлт, хаалт зэрэгт шаардагдах хөрөнгийн талаар **тодорхой тусгасан байх;**”, мөн “Уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам”-ын 3.1-д /Төсөл хэрэгжүүлэгч нь Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хүргүүлэх хайгуулын ажлын үр дүнгийн тайлан, тухайн ордыг ашиглах болон үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлдээ Ашигт малтмалын тухай хуулийн 26.2.3, 27.1.12-т заасны дагуу хаалтын менежментийн **урьдчилсан төлөвлөлтийн талаар тусгана.**/ гэж тус тус заасан.

1.1.2.4. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн ТЭЗҮ-д нөхөн сэргээлтийн нийт ажлын тоо хэмжээ, зардлыг тойм байдлаар тусгасан байна. Өөрөөр хэлбэл жил бүр хийгдэх нөхөн сэргээлтийн ажлын тоо хэмжээ, холбогдох зардлыг дэлгэрэнгүй тусгадаггүй байна. Энэ нь “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 2.10 дахь “**Ашигт малтмалын ордыг олборлох төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа уурхайн хаалтын арга хэмжээнээс тухайн жилд гүйцэтгэх ажлыг тусгана.**” заалт хэрэгжихгүй байхад нөлөөлж байна. Төслийн хугацааны явцад жил бүр хэрэгжүүлэх нөхөн сэргээлтийн ажлын тоо хэмжээ, зардлын дүнг ТЭЗҮ-д тодорхой тусгаагүйн улмаас явцын нөхөн сэргээлт хийгдэхгүй байх, улмаар нөхөн сэргээлтийн ажил уурхай хаагдах хүртэл хуримтлагдах сөрөг үр дагавартай байна.

1.1.2.5. Жил бүр хэрэгжүүлэх нөхөн сэргээлт буюу явцын нөхөн сэргээлтийн ажлын тоо хэмжээ, зардлын дүнг ТЭЗҮ-д тусгахтай холбоотой заалт, зохицуулалт одоогийн мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн актын хувьд илүү нарийвчлан зохицуулах шаардлагатай байна. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг авч үзэхэд уурхайн хаалтын урьдчилсан төлөвлөгөөнд тавигдах шаардлагатай холбоотой заалт, зохицуулалт ороогүй байна. Иймд уурхайн хаалтын урьдчилсан төлөвлөгөөнд явцын нөхөн сэргээлтийн талаар тодорхой тусгаж байх буюу жил бүр хэрэгжүүлэх нөхөн сэргээлтийн ажлын тоо хэмжээ, зардлын дүнг нарийвчлан тооцоолж тусгасан байх зохицуулалтыг Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгуулах нь зүйтэй байна.

А.2. Хайгуулын төслийн “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө”-г хянуулах, батлуулах үйл явцыг цахим системээр гүйцэтгүүлэх шаардлагатай байна.

А.2.1. Хайгуулын төслийн “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө”-г хянуулах, батлуулах үйл явцыг цахим системээр гүйцэтгүүлж, батлагдсан төлөвлөгөөг иргэд олон нийтэд нээлттэй байршуулах шаардлагатай байна.

1.2.1.1. Ашигт малтмалын хайгуулын 20 тусгай зөвшөөрөл эзэмшигч 2022 оны байдлаар Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулсан байна. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нар тухайн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хайгуулын ажлын төлөвлөгөөнд үндэслэн боловсруулж, сумын байгаль орчны байцаагч, мэргэжилтнээр хянуулан сумын Засаг даргаар батлуулдаг эрх зүйн зохицуулалттай.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нар агаар, хөрс, гадаргын болон газар доорх усны бохирдлоос сэргийлэх болон соёлын өвийг хамгаалах чиглэлээр дараах төрлийн арга хэмжээнүүд тусгадаг байна. Тухайлбал:

- Хайгуулын цооногууд руу явсан замыг услах, өрөмдлөгийн үед үүсэх тоос, хорт хийн хэмжээг багасгах,
- Хайгуулын ажлын нөлөөгөөр эвдрэлд орсон хөрсийг нөхөн сэргээх,
- Ургамлын бүрхэвчийг гэмтэхээс сэргийлэх,
- Олон салаа зам гаргахгүй байх, автомашин явах замыг тодорхой тогтоож, тэмдэгжүүлэх, сайжруулах
- Хайгуулын талбайн ойр орчимд хатуу ба шингэн хаягдал, нефтийн гаралтай бүтээгдэхүүн хаяхгүй байх гэх мэт арга хэмжээг байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгадаг байна.

1.2.1.2. Харин аймгийн БОАЖГ болон сумын байгаль орчны байцаагч, мэргэжилтнүүд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн жилийн батлагдсан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний 1 хувийг өөрийн байгууллагад тухай бүр авч үлддэггүй, баримт бичгийн бүрдэл дутуу, хадгаламжийн нэгж үүсгэн архивладаггүй байна. Энэ нь төрийн байгууллага, албан хаагчдын зүгээс хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах үүргийн хэрэгжилтэд тавих хяналтын үр нөлөөг бууруулах сөрөг үр дагавартай байна. Иймд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө”-г хянуулах, батлуулах үйл явцыг цахим системээр гүйцэтгүүлж, батлагдсан төлөвлөгөөг иргэд олон нийтэд нээлттэй байршуулах шаардлагатай байна.

А.2.2. Хайгуулын төсөл хэрэгжүүлэгчдийн 60 хувь нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлын 50 хувийг байршуулсан байна.

1.2.2.1. Хайгуулын 20 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 12 тусгай зөвшөөрөл эзэмшигч нь харьяалах сумын холбогдох дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулсан бөгөөд бусад 8 хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч байршуулаагүй байна.

Хүснэгт 3. Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлын 50 хувийн байршуулалт

№	Талбайн нэр	Сумууд	Эзэмшигч	Байршуулсан мөнгөн дүн /мянган төгрөг/
1	Баавхай уул	Наран, Онгон	Ион энерги	4,125.00
2	Хэрмийн цагаан өндөр	Эрдэнэцагаан	Монгол ураниум ресурс	750.00
3	Баян хушуу	Эрдэнэцагаан	Ижил мөнх тал	250.00
4	Жаран-2	Эрдэнэцагаан	Ижил мөнх тал	250.00
5	Тал булаг	Сүхбаатар	Кинзроуд	1,000.00
6	Бухт-2	Сүхбаатар	Мөнх-Ачлал	250.00
7	Эрдэнэ	Сүхбаатар	Нүүрс хими технологи	500.00
8	Хажуу улаан	Эрдэнэцагаан	Сайхантөмөрт	150.00

9	Дэрст толгой-1	Эрдэнэцагаан	Намуунтод	1,500.00
10	Дэрст толгой-2	Эрдэнэцагаан	Намуунтод	1,350.00
11	Хөх чулууын ам-1	Эрдэнэцагаан	Уулсноён	430.00
12	Хөх чулууын ам-2	Эрдэнэцагаан	Уулсноён	675.00

Эх сурвалж: Сумын ЗДТГ, тусгай зөвшөөрөл эзэмшигчид

1.2.2.3. Эрдэнэцагаан сумын Хөөврийн тал нэртэй газар хайгуулын тусгай зөвшөөрөлтэй “Бичигт шим майнинг” ХХК нь ашиглалтын тусгай зөвшөөрөл болгосон, Сүхбаатар сумын Цагаан толгой, Эрдэнэцагаан сумын Бухт-3 нэртэй газар тусгай зөвшөөрөлтэй “С сайн” ХХК нь тусгай зөвшөөрлөө зарсан, бусад 5 хайгуулын тусгай зөвшөөрөлтэй компани нь хайгуул хийгээгүй шалтгаанаар зардлын 50 хувьтай тэнцэх мөнгөн хөрөнгийг орон нутгийн холбогдох дансанд байршуулаагүй байна.

1.2.2.4. Харин 12 тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг харьяалах сумын холбогдох дансанд нийт 11.2 сая төгрөгийг байршуулсан байна.

БҮЛЭГ Б. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө болон нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хэрэгжилт, түүнд тавих шат шатны хяналт үр дүнгүй байна.

Б.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдээс дүйцүүлэх арга хэмжээ болон мод тарих арга хэмжээнүүд бүрэн хэрэгжээгүй байна.

Б.1.1. Ашигт малтмалын ашиглалтын төсөл хэрэгжүүлэгчийн БОМТ-ний хэрэгжилтийг дүгнэх хуудсаар өгсөн санал дараа жилийн БОМТ-д тусгагддаггүй, зарим дүйцүүлэх арга хэмжээ болон модны тарилт хангалтгүй байна.

2.1.1.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг БОАЖГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 4-р хавсралтын Б маягт-/Уул уурхайн олборлолт, газрын тос, уламжлалт бус газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын хайгуулын төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх хуудас/-ын дагуу жил бүр 10 үзүүлэлтээр 100 хүртэл оноогоор дүгнэдэг байна.

2.1.1.2. Тус ажлын хэсэг мөн дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгах саналыг өгдөг боловч өгсөн санал, зөвлөмжүүд дараа жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд батлагддаггүй байна. Тухайлбал “Цайрт минерал” ХХК-ийн 2022 оны БОМТ-ний биелэлтийг ажлын хэсэг дүгнээд овоолгыг 25 градусын налуу болгох техникийн нөхөн сэргээлт хийх зөвлөмж өгсөн боловч 2023 оны батлагдсан БОМТ-нд тус санал тусгагдаагүй байна.

2.1.1.3. Цайрт минерал ХХК, Говьмастер ХХК, Каскэйд майнинг ХХК, Хунт өгөөж ХХК, Монгол жүанли ХХК, Олгой булаг ХХК-иудын 2022 оны БОМТ-ий биелэлтийг ажлын хэсэг хангалттай гэж дүгнэсэн бөгөөд Нагааранз ХХК, Дорнын чулуулаг ХХК-иудын хэрэгжээгүй арга хэмжээнүүдийг бүрэн гүйцэтгүүлсний дараа биелэлтийг хүлээн зөвшөөрсөн байна. Харин Эрээн толгой ХХК-ийн хувьд 2021 оны БОМТ-ийн биелэлтийг ажлын хэсэг хангалтгүй гэж дүгнэснийг тус компани хүлээн зөвшөөрөөгүйн улмаас БОАЖЯ-ны ажлын хэсэг 2022 оны 9 сард ирж ажиллаад БОМТ-ий биелэлтийг хангалттай гэж дүгнэсэн байна. Үүнтэй холбоотойгоор 2022 оны БОМТ батлагдаагүй байна. Бусад 9 уурхайн хувьд үйл ажиллагаа явуулаагүй шалтгаанаар БОМТ-г батлуулаагүй байна.

2.1.1.4. “Хайгуул, уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээг хүргүүлэх, ирүүлэх, хүлээн авах заавар”-н 4-р хавсралтаар батлагдсан “Уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны тайланд тавигдах шаардлага”-ын “Байгаль орчин, нөхөн сэргээлт”-ийн 10-р маягтаар тухайн онд хэрэгжүүлсэн техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн тоо хэмжээг тайлагнадаг байна. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн дийлэнх нь дээрх тайланд 2022 онд уулын ажил явуулаагүй тул нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй гэж тайлагнажээ.

2.1.1.5. Харин Цайрт минерал ХХК 0.5 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт, Нагааранз ХХК 8.3 га талбайд биологийн нөхөн сэргээлт, Говь мастер ХХК 2.0 га талбайд нөхөн сэргээлт, Дорнын чулуулаг ХХК 9.03 га талбайд биологийн нөхөн сэргээлт, Каскейдмайнинг ХХК 0.7 га талбайд техникийн нөхөн сэргээлт тус тус хийж гүйцэтгэсэн байна.

2.1.1.6. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан дүйцүүлэн хамгаалах ажил зарим уурхай бүрэн хийж хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал Бадмаараг хаш ХХК-ийн хувьд 2022 оны БОМТ-нд тусгагдсан “Далай булаг” гэдэг газарт 1 га, “Хошуун говь” гэдэг газарт 2.6 га дүйцүүлэн хамгаалах ажлыг хийж хэрэгжүүлээгүй байна.

2.1.1.7. Мөн БОМТ-нд “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих ажил тусгагддаг бөгөөд нэг уурхай жилд дунджаар 10,000 мод тарихыг АЗДТГ, БОАЖГ-аас үүрэг болгосон бөгөөд 2022 онд Цайрт минерал ХХК 10,000 мод, Нагааранз ХХК 50 мод, Говь мастер ХХК 500 мод, Олгой булаг ХХК 1100 мод, Хунт өгөөж ХХК 3000 мод, Дорнын чулуулаг ХХК 2500 мод, Каскейд майнинг ХХК 1000 мод тус тус тарьсан байна. Эрдэнэцагаан сумын хувьд 2022 оны “Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-нд мод тарих газрын байршил батлагдаагүй шалтгааны улмаас тус суманд үйл ажиллагаа явуулж байгаа уурхайнуудын мод тарих ажил 2022 онд хэрэгжээгүй байна.

Б.1.2. Хайгуулын төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг батлагдсан хуудсаар дүгнээгүй байна.

2.1.2.1. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг бүрэн биелүүлээгүй үндэслэлээр барьцаа хөрөнгийг зарцуулсан тохиолдол гараагүй байна. Харин “Хайгуул, уулын ажлын болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээг хүргүүлэх, ирүүлэх, хүлээн авах заавар”-н 2-р хавсралтаар батлагдсан “Хайгуулын ажлын тайланд тавигдах шаардлага”-ын “Байгаль орчны нөхөн сэргээлтийн мэдээ”-ний 7-р маягтаар нөхөн сэргээлт хийсэн талбайн байршил, ажлын тоо хэмжээг хүлээн авч, сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч гарын үсэг, тэмдгээр баталгаажуулдаг байна.

2.1.2.2. Хайгуулын 20 тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд 2022 онд үйл ажиллагаа явуулснаас хайгуулын талбайд өрөм тавьж, газар хөндөөгүй буюу бусад арга хэлбэрээр хайгуул хийсэн 12 тусгай зөвшөөрөл эзэмшигч байна. Харин хайгуулын талбайд өрөм тавьж хайгуул хийсэн 8 тусгай зөвшөөрөл эзэмшигч байна. Эдгээр нь хайгуул хийсэн талбайд нөхөн сэргээлт хийж, талбайг хүлээлгэн өгсөн байна.

2.1.2.3. “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 4-р хавсралтын А маягт-/Газрын тос, уламжлалт бус газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалаас бусад ашигт малтмалын хайгуулын төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх хуудасны загвар/-ын дагуу 5 үзүүлэлтээр 100 хүртэл оноогоор дүгнэх журмын зохицуулалттай байхад энэхүү маягтаар хайгуулын төслийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг дүгнэдэггүй байна.

2.1.2.4. Иймд хайгуулын төслийн тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг баталсан албан хаагч нар тухайн жилийн “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлт”-ийг батлагдсан маягтаар жил бүр дүгнэж байх шаардлагатай байна.

Б.2. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагаанд шат шатны байгууллагууд хяналт тавьж байгаа боловч түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалттай холбоотой асуудал хүндрэл үүсгэж байна.

Б.2.1 Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан боловч орон нутагт хүлээлгэж өгөөгүй эвдрэлд орсон талбайд байгаль орчны хохирлын үнэлгээ хийлгэж, нөхөн сэргээлтийн ажил хийгээгүй зөрчил илэрлээ.

2.2.1.1. Аймгийн БОАЖГ-ын байгаль орчны хяналтын улсын байцаагч болон АЗДТГ-ын Геологи, уул уурхай, газрын тос, хийн хяналтын улсын байцаагч нар 2023 онд уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөрчилтэй ААНБ-уудад зөрчил арилгуулах улсын байцаагчийн албан шаардлага өгч, торгууль ногдуулсан байна. Тухайлбал Байгаль орчны хяналтын улсын байцаагч “Премиумкөүл” ХХК БОМТ-өөгүй үйл ажиллагаа явуулсан зөрчилд торгууль ногдуулж, “Андын илч” ХХК-ийн уурхайн талбайд үндсэн баримт бичиг байлгаагүй зөрчил гаргасан тул үйл ажиллагааг түр зогсоосон байна. Геологи, уул уурхай,

газрын тос, хийн хяналтын улсын байцаагч 12 уурхайд хяналт шалгалт хийж 10 уурхайд 56 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, “Монгол жүанли” ХХК-д аюулгүй ажиллагааг хангаж ажиллаагүй зөрчилд 3.0 сая төгрөгийн торгууль ногдуулсан байна.

2.2.1.2. Зөвшөөрөлгүйгээр газар ашигласан буюу тусгай зөвшөөрлийн талбайн гадна талд газар ашиглаж, эвдрэлд оруулсан “ЭБЭ” ХХК, “Монгол жүанли” ХХК-тай холбоотой 2 асуудал хууль хяналтын байгууллагад шилжин, эрүүгийн хэрэг нээгдэж, шалган шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.

2.2.1.3. Сүхбаатар аймгийн эвдэрсэн газрын тооллого 2018 онд хийгдсэн бөгөөд эвдэрсэн газрын тооллогоор 59 байршилд 881.6 га газар эвдрэлд орсныг тоолж, баримтжуулсан байна. Тус тооллогыг хийснээс хойш орон нутгийн төсвийн хөрөнгөөр 5 байршилд нийт 0.8292 га талбайд, уул уурхайн компаниудаар дүйцүүлэх арга хэмжээний хүрээнд 6 байршилд нийт 17.327 га талбайд тус тус техникийн нөхөн сэргээлт хийсэн байна.

2.2.1.4. Тухайн эвдрэлд орсон газруудад үйл ажиллагаа явуулж байсан ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй зарим компаниудын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж, нөхөн сэргээлт хийгээгүй, талбайг хүлээлгэж өгөөгүй хаяж явсан компаниуд байна. Тухайлбал хайлуур жоншны ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Нанжид” ХХК 0.5 га газрыг, хайлуур жоншны хайгуулын тусгай зөвшөөрөлтэй “БХЛ” ХХК 0.227 га газрыг, “Бигэр мандал” ХХК 1.1 га газрыг тус тус эвдрэлд оруулсан гэж 2018 оны тооллогоор тоологдсон байна. Гэтэл дээрх компаниуд тусгай зөвшөөрлийн хугацаа дуусмагц, нөхөн сэргээлт хийж, орон нутагт хүлээлгэн өгөлгүйгээр орхиж явсан байна. Энэ асуудлаар 2020 онд Мөнххаан сумын Засаг даргад “Нөхөн сэргээлтийн арга хэмжээ зохион байгуулах тухай” албан бичиг, Сүхбаатар аймгийн Цагдаагийн газарт “Хамтран ажиллах тухай” албан бичгийг тус тус хүргүүлсэн боловч үр дүн гараагүй байна. Иймд эдгээр компаниудын байгаль орчинд учруулсан хохирлыг хэмжээг тогтоолгох, нөхөн сэргээлтийг хийлгэх, эсхүл хохирлыг нөхөн төлбөрийг гаргуулж мэргэжлийн байгууллагаар нөхөн сэргээлт хийлгэх шаардлагатай байна.

2.2.1.5. Орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх нийцлийн аудитаар уул уурхайн компаниудын хөрсний усыг үйлдвэрлэлд ашиглах болон шавхан зайлуулахтай холбоотой дараах зөрчлийг илрүүлсэн бөгөөд төлбөрийн акт тогтоох, алдаа зөрчлийг арилгуулах захиргааны шийдвэр гаргахаар ажиллаж байна. Үүнд:

- Эрдэнийн олз ХХК нь уурхайн карьерт үүссэн хөрсний усны хэмжээг Жи Эн Эн Эс Суврэй ХХК-аар тогтоолгон 153,323 м3 усыг Буйр нуур-Мэнэнгийн талын сав газрын захиргааны шийдвэр гаргуулан төлбөр төлөхгүйгээр шавхан зайлуулсанд 119.1 сая төгрөг төлөөгүй;
- Цайрт минерал ХХК, Эрээн толгой ХХК зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг Усны тухай хуулийн 31.2, Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу шатлан өсгөх хэлбэрээр төлөөгүйгээс төсөвт 47.6 сая төгрөг дутуу төвлөрүүлсэн;

- Хунт-Өгөөж ХХК тоолуургүйгээр шавхалтын усыг зайлуулсан зөрчлийг эрх бүхий байгууллагад мэдэгдэж зөрчлийн хэрэг нээлгэсэн.

“Нагааранз” ХХК нь уурхайн талбайн аюулгүй байдлыг хангах ажлыг төлөвлөж зохион байгуулаагүй нь “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 39.1.4.3 дахь заалт /уурхайн хаягдлын далан барих, уурхайн талбайн аюулгүй байдлыг хангах/-ыг зөрчсөнд хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

2.2.1.6. Асгат сумын нутагт үйл ажиллагаа явуулж байгаа Дорнын чулуулаг ХХК нь “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 39.1.4.3 дахь заалт /уурхайн хаягдлын далан барих, уурхайн талбайн аюулгүй байдлыг хангах/-ыг хангаж ажиллаагүйгээс сумын 22 малчны 559 толгой бод мал уурхайн нүхэнд унаж хорогдсон байна. Нутгийн иргэдийн хорогдсон малын үнэлгээг Болор үнэлгээ ХХК-иар хийлгэж мөнгөн дүнгийн 50 хувьтай тэнцэх хэмжээний төлбөр болох 329.1 сая төгрөгийг малчдад олгохоор болсон бөгөөд төлбөрийг 2023 оны 12 сарын 01-ний өдөр бүрэн барагдуулахаар малчидтай тохиролцсон байна. Уурхайн талбайн аюулгүй байдлыг хангах ажлыг төлөвлөж зохион байгуулаагүй нь “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 39.1.4.3 дахь заалт /уурхайн хаягдлын далан барих, уурхайн талбайн аюулгүй байдлыг хангах/-ыг зөрчсөнд хугацаатай албан шаардлага хүргүүлээ.

Б.2.2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.

2.2.2.1. Байгалийн баялгийг зөвшөөрөлгүй бэлтгэсэн, олборлосон, эсхүл байгаль орчны чадавхын тогтоосон хэм хэмжээ, зөвшөөрөгдөх дээд хэмжээний хязгаараас хэтрүүлэн байгаль орчныг бохирдуулсан, доройтуулсан, гэмтээсэн, байгалийн нөөц баялгийг хомсдуулсан, экологийн тогтолцоог алдагдуулсан аливаа үйлдэл, эс үйлдэхүйг "байгаль орчинд учруулсан хохирол" гэж Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11-д заажээ.

2.2.2.2. Сүхбаатар аймагт түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах 6 тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаа боловч БОНБНУ болон дагалдах бусад баримт бичгүүд батлагдаагүй, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн дутагдал зэрэг шалтгааны улмаас хууль тогтоомжид заасны дагуу ашиглалтын үйл ажиллагаа явуулах боломжгүй байна. Гэтэл улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй зам, барилгын ажил, Бага-Өлгий ХХК, Сэвүүн уудам тал ХХК-ийн зуурмагийн үйлдвэрүүд, хувийн хэвшлийн орон сууц болон бусад барилгын ажилд хайрга, дайрга, элсийг зөвшөөрөлгүйгээр ашиглаж байгаа нь хуульд нийцэхгүй байна. Тухайлбал Монгол зам ХХК нь Баруун-Уртын соёл амралтын хүрээлэнгийн ажилд түгээмэл тархацтай ашигт малтмалыг зөвшөөрөлгүйгээр ашиглаж байна. Мөн Шарга ХХК нь хайгуулын зөвшөөрөлтэй боловч хайгуулын талбайгаас элсийг аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд худалдан борлуулж, зөвшөөрөлгүй ашиглаж байна.

2.2.2.3. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 25.3-т /Түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Ашигт малтмалын тухай хуулийн 35.3.1-35.3.7-д заасан баримт бичгийг бүрдүүлнэ/ гэж заасны дагуу Олон дайна ХХК, Бага-Өлгий ХХК, Сэвүүн уудам тал ХХК нь БОНБҮ-гүй, орд газрыг ашиглах уулын ажлын төлөвлөгөөгүй, уурхайг хүлээн авсан улсын комиссын шийдвэргүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй, Аймаг, сумын Засаг даргатай гэрээ байгуулж ажиллаагүй, ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлөөс өөр бичиг баримтгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаа нь Ашигт малтмалын тухай хуулийн 35-р зүйлийн 35.3.2, 35.3.3, 35.3.4, 35.3.6, 35.3.7, 37-р зүйлийн 37.2, 42-р зүйлийн 42.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.

2.2.2.4. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 3.3, 8.2-т заасны дагуу Засгийн газрын 2021 оны 214 тоот тогтоол гарч Баруун-Урт сумын нутаг дэвсгэрээс 83 мянган м3, Сүхбаатар сумын нутаг дэвсгэрээс 22 мянган м3 түгээмэл тархацтай ашигт малтмал хайх, ашиглах зөвшөөрлийг аймгийн 4-р тойргийн 9.1 км, 5-р тойргийн 5.65 км, Баруун-Урт сумын сувилал чиглэлийн 3.03 авто замыг барихтай холбоотой Ханан салхит ХХК зөвшөөрөл өгсөн. Харин Мөнххаан сумын төвд 3.6 км, Халзан сумын төвд 2.5 км, наадмын талбай хүртэл 1.5 км, эко хороолол дотор 0.56 км, аймгийн төвийн замд нөхөөс хийж засварлахад 116м2 асфальтад түгээмэл тархацтай ашигт малтмал зөвшөөрөлгүй ашиглаж Засгийн газрын тогтоолыг зөрчсөн байна.

2.2.2.5. Аймгийн ИТХ нь Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 3.3 заалт /Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглахтай холбогдсон харилцааг Засгийн газраас баталсан тусгай журмаар зохицуулж болно./ болон Засгийн газрын 2014 оны 222 тогтоолын хавсралтын 3.4.2. /түгээмэл тархацтай ашигт малтмалын борлуулалтын үнэлгээг тогтоох, өөрчлөх/ заалтын дагуу тогтоол гаргаагүй байна. Бусад аймгийн жишгээс харвал Дархан-Уул аймаг 2019 онд /Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км автозамын өргөтгөл, шинэчлэлтийн ажилд шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр тооцох борлуулалтын 1 шоо метрийн үнэлгээг 5000 төгрөгөөр тогтоосугай/, Говь-Алтай аймаг 2015 онд /Аймгийн нутаг дэвсгэрт улсын чанартай автозам, замын байгууламж барих, засварлахад ашиглах 1 шоо метр түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох борлуулалтын үнэлгээг 5000 төгрөгөөр тогтоосугай/ гэж тогтоолд заажээ. Иймд ИТХ-аас тогтоол гаргаж түгээмэл тархац ашигласан төлбөрийг улсын чанартай төсөл, арга хэмжээний ажил хийж буй Ханан салхит ХХК-иас Засгийн газрын тогтоосон хэмжээгээр тогтоол гаргаж нөхөн төлүүлбэл 13.1 сая төгрөг төсөвт төвлөрүүлэх боломж байна. Мөн зөвшөөрөлгүй ашигласан бусад зам барих төсөл

арга хэмжээнд ашигласан түгээмэл тархацтай ашигт малтмалаас орлого орох боломжтой байна.

2.2.2.6. Аймгийн хэмжээнд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын лицензтэй 11 аж ахуйн нэгж байгаагаас Асгат сумын Ар цахилдаг нэртэй газар 2 тусгай зөвшөөрөлтэй “Зэт энд эйч юу” ХХК, Сүхбаатар сумын Элстэй, Шанаган, Хүрмэн нэртэй газруудад 3 тусгай зөвшөөрөлтэй “Ноёдын ноён хөндий” ХХК нь үйл ажиллагаа явуулаагүй учир тусгай зөвшөөрөл цуцлагдсан байна. Эрдэнэцагаан сумын Хадан хөв нэртэй газар 2 тусгай зөвшөөрөлтэй “Үлэмж-Агро” ХХК хайгуулын үйл ажиллагаа эхлэх гэсэн боловч нутгийн иргэд эсэргүүцэж үйл ажиллагаа нь түр зогссон байна. Сүхбаатар сумын нутагт хайгуул хийх зөвшөөрөлтэй “Теллюс” ХХК, “Бөөндий” ХХК, Эрдэнэцагаан сумын нутагт зөвшөөрөлтэй “Хэрлэн-Од” ХХК-иуд нь үйл ажиллагаа явуулаагүй байна. Асгат сумын нутагт тусгай зөвшөөрөлтэй “Шарга” ХХК нь ашиглалтын тусгай зөвшөөрөл авахаар болсон байна.

БҮЛЭГ В. Уурхайн хаалт ба нөхөн сэргээлтэд зориулан нөөц сан байгуулаагүй, Аймаг, сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүй, ААНОАТ-ын орон нутагт төвлөрөх 40 хувийг Сангийн яам олгоогүй байна.

В.1. Уурхайн хаалт ба нөхөн сэргээлтэд зориулан нөөц сан байгуулаагүй, Аймаг, сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

В.1.1 Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниуд "уурхай, уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журам"-д заасан уурхайн хаалт ба нөхөн сэргээлтэд зориулан нөөц сан байгуулаагүй байна.

3.1.1.1. “Цайрт минерал” ХХК-ийн ТЭЗҮ-д тусгагдсан 13.0 тэрбум төгрөгийн хаалтын зардлыг үндэслэн санхүүгийн тайландаа дээрх дүнгээр холбогдох стандарт, зааврын дагуу урт хугацаат өр төлбөрийн хэсэгт Нөөц/өр төлбөр/ дансанд бүртгэсэн байна. Бусад уурхайнуудын санхүүгийн тайланд нөөц санг бүртгээгүй байна. Тухайлбал: “Эф жи пи эм” ХХК, “Хунт өгөөж” ХХК, “Говь мастер” ХХК, “Кинзроуд” ХХК, “Каскейд майнинг” ХХК, “Бадмаараг хаш” ХХК, “Эрдэнийн босго” ХХК, “Эрдэнийн олз” ХХК, “Эрээн толгой” ХХК, “Нагааранз” ХХК, “Олгой булаг” ХХК-иуд НББ-д нөөц сан байгуулж бүртгэлд тусгаагүй байна.

3.1.1.2. Санхүүгийн тайланд нөөц санг бүртгээгүй байгаа нь “Хайгуул ба олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандарт”-тай нийцэхгүй байна. Үүнд:

1. Аж ахуйн нэгж нь хөрөнгийг олж бэлтгэх, барьж байгуулах, бүтээн байгуулах эсвэл хөрөнгийн энгийн үйл ажиллагааны үед түүнийг ашиглалтаас гаргах үүрэг хариуцлага, мөн хүрээлэн буй орчны хэвийн төрхийг алдагдуулах үед түүнийг нөхөн сэргээлттэй холбоотойгоор гэрээний, хуулийн эсвэл үүсмэл

үүрэг хариуцлага үүсдэг. Үүний биелэлтэд зориулж нөөц сан байгуулна гэж заасантай нийцэхгүй байна.

2. Уурхайн хаалт ба нөхөн сэргээлтэд зориулан нөөц сан байгуулах НББОУС 37 Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө стандартын дагуу нөөц санг байгуулж бүртгэлд тусгана. Нөөц гэдэг нь цаг хугацаа эсвэл дүнгийн хувьд тодорхой бус өр төлбөр юм. Нөөц санг ирээдүйд зардал гарах валютаар байгуулах шаардлагатай.
3. Нөөцийг дараах тохиолдолд хүлээн зөвшөөрнө: Өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн үүрэг хариуцлага (хуулийн дагуу эсвэл үүсмэл) хүлээсэн; Уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн урсгал гарна гэдэг нь магадлалтай болсон; Үүргийн дүнг найдвартай тооцоолох боломжтой;
4. Нөөцөөр хүлээн зөвшөөрөх дүн нь тайлангийн өдрөөрх өнөөгийн үүрэг хариуцлагыг биелүүлэхэд шаардлагатай зарлагын хамгийн сайн тооцоолол байх ёстой. Өөрөөр хэлбэл, аж ахуйн нэгж нь тайлангийн өдрөөр тухайн үүргийг биелүүлэх эсвэл зохих ёсоор гуравдагч талд шилжүүлэхийн тулд төлөх дүн байна гэж заасантай доорх компаниуд нийцэхгүй байна.

3.1.1.3. Иймд нөөц сан байгуулж бүртгэлд тусгаагүй тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг баталгаажуулахгүй, хүлээн авахгүй байж НББОУС-37 болон хайгуул ба олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн бодох стандартыг мөрдөж ажиллах шаардлага үүсэж байна.

В.1.2 Аймаг, сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилт хангалтгүй байна.

3.1.2.1. Аймгийн нутагт дэвсгэрт ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагатай Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-т заасны дагуу ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор хамтран ажиллах гэрээг байгуулсан байна.

3.1.2.2. Хамтран ажиллах гэрээний хүрээнд 532.8 сая төгрөгийг 6 аж ахуйн нэгж, байгууллагаас орон нутгийн төсөвт төвлөрүүлээд байна. Харин дараах аж ахуйн, нэгж байгууллага гэрээний үүргийг хэрэгжүүлээгүйгээс, гэрээнд тусгагдсан төлбөрийг бүрэн төвлөрүүлээгүй байна.

Хүснэгт 4. Аймаг, сумын Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт

	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	2022 оны гэрээ		2023 оны гэрээ		Төлбөрийн акт тогтоосон мөнгөн дүн (сая төг)
		огноо	мөнгөн дүн (сая төг)	огноо	мөнгөн дүн (сая төг)	
1	Андын илч ХХК			2023.05.08	350.0	265.0
2	Бадмаараг хаш ХХК	2022.03.28	300.0	2023.05.08	200.0	240.0
3	Олгой булаг ХХК	2022.03.28	305.0	2023.05.08	50.0	186.0
4	Эрдэнийн босго ХХК			2023.05.08	200.0	200.0
5	Эрээн толгой ХХК			2023.05.08	240.0	240.0

6	Каскейд майнинг ХХК	2022.03.28	27.0	2023.05.08	80.0	88.2
	ДҮН		632.0		1,120.0	1,219.2

Эх сурвалж: Аймаг, сумын CTCX болон уул уурхайн компаниуд

3.1.2.3. Гэрээнд тусгасан орон нутгийн төсөвт дутуу төвлөрүүлсэн 1219.2 сая төгрөгийг дээрх 6 тусгай зөвшөөрөл эзэмшигчээр төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

3.1.2.4. Аймгийн Хөрөнгө оруулалт, хөгжлийн чуулган зохион байгуулахтай холбоотойгоор 2023 оны хамтран ажиллах гэрээнд тусгайлан заалт оруулан “Эрээнтөлгой” ХХК 30.0 сая, “Бадмаараг хаш” ХХК 20.0 сая, “Хунт Өгөөж” ХХК 10.0 сая, Олгойбулаг ХХК 20.0 сая, “Каскейд майнинг” ХХК 10.0 сая, “МДМУ” ХХК 8.0 сая, “Эм Эл цахиурт овоо” ХХК 20.0 сая, “Эрдэнийн босго” ХХК 20.0 сая төгрөг нийт 138.0 сая төгрөг, Дарьганга сумаас бусад 12 сумаас 28.1 сая төгрөгийг “Нүүдэлчдийн агуулга” НҮТББ-ын дансаар шилжүүлэн авсан бөгөөд дансны хуулгыг авч үзэхэд хөрөнгө оруулалт, хөгжлийн чуулганд зарцуулсан эсэх нь тодорхойгүй, хувь хүний дансаар зарцуулсан байх тул нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх шаардлага үүссэн.

3.1.2.5. “Алаг тогоо” ХХК нь Аймаг, сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээгээр 2021 онд 30.0 сая, 2022 онд 30.0 сая төгрөгийг аймгийн төрийн сан банкны бусад орлогын 100120000955 тоот дансанд, Сүхбаатар суманд шилжүүлэх 20.0 сая төгрөгийн сумын төрийн сан банкны бусад орлогын 100120700955 тоот дансанд шилжүүлэхээр тусгасан боловч аймаг, сумын төрийн сангийн дансанд шилжүүлээгүй байна. “Алаг тогоо” ХХК-ийн хамтран ажиллах гэрээнд тусгагдаагүй 120.0 сая төгрөгийг “Тэнгэр трэвел” ХХК-ийн дансанд сургалт, аяллын зардал гэсэн гүйлгээний утгатайгаар шилжүүлсэн бөгөөд 29 иргэнийг БНХАУ-ын Бээжин хотод аялуулсан байна. Энэ нь Ашигт малтмалын тухай хуулийн 42.5 дахь заалт /Нутгийн захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 42.1-д заасан гэрээнд тусгагдаагүй хандив, тусламжийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардахыг хориглоно/-ыг зөрчсөн тул нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх шаардлага үүссэн.

3.1.2.6. “Каксейд майнинг” ХХК Аймаг, сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээний хүрээнд 107.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 5.0 сая төгрөгийг Сүхбаатар сумын ЗДТГ-ын нярвын хувийн дансанд шилжүүлсэн бөгөөд тус 5.0 сая 2022 онд зохион байгуулагдсан Хатиган хошууны наадмын үйл ажиллагаанд зарцуулсан гэх боловч юунд зарцуулагдсан нь тодорхойгүй нөхцөл байдал үүссэн тул нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх шаардлага үүссэн. Мөн 8.8 сая төгрөгийг Сүхбаатар сумын засаг даргын шийдвэрээр Сүхбаатар аймаг байгуулагдсаны 80 жилийн ойн хүрээнд аймгийн угсаатны зүйн музейд ном хэвлүүлэхэд зориулж “Бест колор интернэшнл” ХХК-ны дансанд шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.9.3 дахь заалт /хууль тогтоомжийн дагуу сум, дүүргийн төсөвт орох бусад орлого/, 25 дугаар зүйлийн 25.12 дахь заалт /Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тусламжийн орлогыг төрийн

сангийн нэгдсэн дансанд байршуулна/, Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.5 дахь заалт /Нутгийн захиргааны болон бусад байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 42.1-д заасан гэрээнд тусгагдаагүй хандив, тусламжийг тусгай зөвшөөрөл эзэмшигчээс шаардахыг хориглоно/-ыг зөрчсөнд албан шаардлага хүргүүлээ.

В.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчд ААНОАТ-ыг тайлагнасан, харин борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, төлсөн татварыг олон нийтэд мэдээлээгүй байна.

В.2.1. Сангийн яам орон нутагт орох орлогыг төвлөрүүлээгүй, уул уурхайн бүтээгдэхүүнийг Монголын хөрөнгийн биржээр арилжаалах шаардлагатай байна.

3.2.1.1. Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч компаниудын 2022 оны санхүүгийн тайланд илэрхийлсэн татварын өмнөх ашиг болон орлогын албан татварын зардалд дүн шинжилгээ хийж үзэхэд үйл ажиллагаа явуулж байгаа 18 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн 5 нь 2022 онд ашигтай ажиллаж, нийт 46.4 тэрбум төгрөгийн аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөхөөр тайлагнасан байна.

3.2.1.2. Төсвийн тухай хуулийн 23.6.10-т заасны дагуу ААНОАТ-ын 40 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх зохицуулалттай боловч эдгээр уурхайнуудаас зөвхөн Цайрт минерал ХХК орон нутагт бүртгэлтэй, бусад уурхайнууд Улаанбаатар хотод бүртгэлтэй байна. Цайрт минерал ХХК нь орон нутагт бүртгэлтэй боловч Сангийн яам тус компанийн төлсөн ААНОАТ-ын 40 хувь болох 18.5 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй байна. Бусад компаниудын хувьд Аймаг, сумын Засаг даргатай байгуулсан хамтарсан гэрээнд тусгасан “орон нутагт бүртгэлтэй салбар нэгж байгуулах” заалт хэрэгжээгүй байна.

3.2.1.3. Хүрэн нүүрсний ордын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 9 уурхайн 2022 онд экспортолсон тоо хэмжээ, санхүүгийн тайлан дахь борлуулалтын орлогын мэдээлэлд үндэслэн нэг тонн нүүрсэд ногдох борлуулалтын орлогыг тооцож гаргасан бөгөөд дунджаар нэг тонн нүүрсийг 48.5 мянган төгрөгөөр борлуулсан байна. Улмаар АМГТГ-аас 2022 онд зарласан олон улсын зах зээлийн үнийн мэдээллээс 1 тонн нүүрсний 2022 оны дундаж үнийг тооцоолж гаргахад 144.6 мянган төгрөг байна. Өөрөөр хэлбэл 1 тонн нүүрсийг зах зээлийн үнийн 33.5 хувиар борлуулсан байна.

Хүснэгт 5. Нэг тонн нүүрсний борлуулалтын орлого ба зах зээлийн үнийн харьцаа

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Борлуулалтын орлого /мянган төгрөг/	Экспортод гаргасан тоо хэмжээ /тонн/	Экспортод гаргасан нэгж бүтээгдэхүүнд ногдох орлого /мянган төгрөг/	Олон улсын зах зээлийн үнэ /мянган төгрөг/	Зах зээлийн үнэтэй харьцуулсан хувь	Тайлбар
1	Андын илч ХХК	869,841.30	3,023.00	287.7	144.6	199	Гаалийн хяналтын талбайн орлого нэмэгдсэн

Байгаль орчин, уул уурхайн нөхөн сэргээлтийн үр дүн

2	Бадмаараг хаш ХХК	593,083.80	10,076.00	58.9	144.6	40.7	
3	Дорнын чулуулаг ХХК	0	131	0	144.6	0	
4	Нагааранз ХХК	49,555.10	866	57.2	144.6	39.6	
5	Олгойбулаг ХХК	1,008,404.30	50,863.00	19.8	144.6	13.7	
6	Премиумкөөл корпораци ХХК	1,243,293.90	42,951.00	28.9	144.6	20	
7	Талын гал ХХК	2,041,132.00	7,307.00	279.3	144.6	193.2	Дотоодод борлуулалт их хийдэг
8	Эрдэнийн босго ХХК	80,823.40	1,899.00	42.6	144.6	29.4	
9	Эрээнтөлгой ХХК	84,607.10	1,010.00	83.8	144.6	57.9	
Нийт дүн		5,970,740.90	118,126.00				

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газрын статистикийн хэлтэс, Сангийн яам

3.2.1.4. Сүхбаатар аймгийн хүрэн нүүрсний уурхайн илчлэг дунджаар 2800-3800 ккал/кг байдаг бөгөөд олон улсын зах зээлийн үнийн хувьд 2500 ккал/кг үзүүлэлттэй буюу хамгийн бага илчлэгтэй нүүрсний үнийн мэдээллийг тооцоололд ашигласан. Дээрх хүснэгтээс харахад нүүрсний экспортын борлуулалтын үнэ зах зээлийн үнээс харьцангуй бага буюу 50 хувьд хүрэхгүй байна.

3.2.1.5. Нүүрс, хайлуур жонш, төмрийн хүдэр зэрэг уул уурхайн бүтээгдэхүүнийг Монголын хөрөнгийн биржээр арилжаалах боломжтой болсон тул Сүхбаатар аймагт үйл ажиллагаа явуулж буй хүрэн нүүрс, төмрийн хүдэр, хайлуур жонш зэрэг уул уурхайн бүтээгдэхүүнийг Монголын хөрөнгийн биржээр арилжаалах зохицуулалтыг Аймаг, сумын Засаг даргатай, уул уурхайн компаниудын хооронд байгуулдаг хамтран ажиллах гэрээнд тусгаж ажиллах боломж, нөхцөл бүрдсэн байна.

В.2.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг хуульд заасан хугацаанд багтаан нийтэд мэдээлээгүй байна.

3.2.2.1. Аймаг, сумын Засаг даргатай тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээний 9 дүгээр зүйлд гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, гэрээний хэрэгжилтийг дүгнэх, тайлагнах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий хамтын ажиллагааны хороо нь Аймаг, сумын Засаг даргатай хамтран ажиллах гэрээг iltodgereee.mn сайтад дутуу мэдээлсэн нь Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.4 дэх заалтад /нутгийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан энэ хуулийн 42.1-д заасан гэрээг олон нийтэд нээлттэй, ил тод байлгана/ гэж заасныг бүрэн биелүүлээгүй байна.

3.2.2.2. Ашигт малтмалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь заалтад /Ашигт малтмалын асуудлаар сумын Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ/, 12.2.2 дахь заалтад /харьяалах нутаг дэвсгэрт эрдэс баялгийн салбарын талаар хэрэгжиж байгаа шийдвэрийн талаар жил бүр олон нийтэд мэдээлэх/ гэж заасны

дагуу тухайн төслөөс гаргадаг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, байгаль орчны тайлангуудыг олон нийтэд мэдээлснээр иргэд байгаль орчны эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг багасгах, хяналт тавихад мэдээлэлтэй болж, хяналт тавих боломж бүрдэх юм.

3.2.2.3. Нийгмийн хариуцлагын асуудлыг орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд тусгасан. Эдгээр нөхцөлийг нийтэлснээр иргэд тухайн төслөөс нийгэмд оруулж буй хувь нэмрийг ойлгоход туслаад зогсохгүй нийгмийн хөтөлбөрүүдийг нь боловсруулахад оролцож, тэдгээрийн үр шимийг хүртэх таатай боломжийг олгож байдаг. Мөн төр засаг ба компаниудын авсан үүрэг амлалтад хяналт тавьж, тэдгээрийн хэрэгжих нөхцөлийг бүрдүүлэх сайн талтай юм.

3.2.2.4. Иймд тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг хуульд заасан хугацаанд багтаан нийтэд мэдээлэх шаардлагатай байна. Мөн орон нутгийн удирдлагаас дээрх мэдээллийг цаг хугацаанд нь иргэдэд мэдээлэх шаардлагыг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагад тавьж хуулийг хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

---oOo---

Холбогдох байгууллагын санал:



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас, факс: 70512121, 70518232

2023.11.28 № 01/1338
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Хариу хүргүүлэх тухай

Танай байгууллагаас “Байгаль орчин, уул уурхайн нөхөн сэргээлтийн үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараах тайлбар, саналыг хүргүүлж байна.

1. 3.2.2.1 Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, Засгийн газрын 2016 оны 179, Аймгийн ИТХТ-ийн хуралдааны 2021 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор батлагдсан гэрээний нөхцөл, чиглэлийн дагуу Аймгийн Засаг даргын 2023 оны А/274 дүгээр захирамжаар тусгай зөвшөөрөл эзэмшигч нартай хамтын ажиллагааны гурвалсан гэрээг байгуулж ажиллаж байна. Гэрээ дүгнэх Хамтын ажиллагааны хорооны ажиллах журмыг 2021 оны аймгийн Засаг даргын А/84 дүгээр захирамжаар баталсан. 2021-2022 онд ковидын болон ковидын дараах хүндрэл, Бичигт боомтын үйл ажиллагаа хаагдсан нөхцөл байдлын улмаас аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаа зогсонги байсан тул гэрээг дүгнэх ажлууд хойшлогдож, 2023 онд байгуулсан Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээнд өмнөх оны гэрээний үүргийг биелүүлэх заалтуудыг оруулсан байна. Орон нутгийн хамтын ажиллагааны байгуулсан гэрээнүүдийг iltodgeree.mn сайтад жил бүр байршуулсан. Засгийн газрын 2012 оны 222 дугаар тогтоолоор Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх үндэсний зөвлөл байгуулагдаж, аймаг сумдад салбар зөвлөл байгуулан уул уурхайн салбарын мэдээлэл, аж ахуй нэгжийн өгсөн хандив тусламж, орон нутагт төлсөн татвар хураамжийн мэдээллийг ил тод мэдээлэх ажлыг зохион байгуулах чиглэл өгсөн. Үүний дагуу аймгийн Засаг даргын 2021 оны А/181 дүгээр захирамжаар аймгийн ОУИБС-ын аймгийн дэд зөвлөл байгуулагдаж салбарын хууль тогтоомж, үйл ажиллагаа, тулгамдаж байгаа асуудал, орон нутгийн хамтын ажиллагаа, аж ахуй нэгжүүдийн төлсөн татвар, хураамж, гэрээний мэдээллийг сумд, иргэдэд ил тод мэдээлэх ажлыг хариуцан ажиллаж байна. Аймгийн Татварын хэлтэс, ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс ОУИБС-ын ажлын албанаас баталсан маягтын дагуу тайлан мэдээллийг заасан хугацаанд гарган хүргүүлдэг. Ажлын алба аж ахуй нэгжүүдээс тайланг авч Нутгийн захиргааны гаргасан тайлантай тулган баталгаажуулж <https://e-reporting.eitimongolia.mn/> сайтад ил тод байршуулан иргэдэд мэдээлэл хүргэх ажлыг дэд зөвлөлүүдтэй хамтран зохион байгуулж байна. “Их бага баян шарга” ТББ-ын тэргүүн Л.Бор дэд зөвлөлд төрийн бус байгууллагын төлөөлөл болж идэвх санаачилгатай ажилладаг ба 2022 онд Баян шарга сонинд аймгийн уул уурхайн тусгай зөвшөөрөл, үйл ажиллагааны мэдээллийг иргэдэд тайлагнах зорилгоор 1000 ширхгийг хэвлүүлж сумдад тараасан.

Жил бүр УУХҮЯ, ОУИБС-ын үндэсний зөвлөлөөс салбарын бүсийн зөвлөгөөн зохион байгуулж байна. ОУИБС-ын аймгийн дэд зөвлөл сумдад сургалт, уулзалт

хэлэлцүүлгийг зохион байгуулж, иргэдэд мэдээлэл хүргэн ажилладаг. 2021-2022 онд аймгийн Баруун-Урт, Асгат, Сүхбаатар, Эрдэнэцагаан, Баяндэлгэр, Түвшинширээ, Уулбаян, Мөнххаан, Түмэнцогт сумдад "Уул уурхайн амьдралын мөчлөг" сэдэвт мэдлэг олгох, мэдээлэл түгээх сургалт, хэлэлцүүлгийг Мерит төслийн сургагч багш нартай, Их бага баян шарга ТББ-ын тэргүүн Л.Бор Сүхбаатар, Эрдэнэцагаан, Уулбаян сумдын ОУИТБС-ын дэд зөвлөлийг чадавхжуулах, мэдлэг олгох сургалт, хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулж сумдын иргэдийн хурал, ЗДТГ, холбогдох мэргэжилтнүүд, иргэд, төгсөх ангийн хүүхдүүд зэрэг 300 гаран төлөөллийг хамруулж оролцуулсан.


Зөвлөмжид өгөх санал:

1. Монгол Улсын засгийн газраас баталсан Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжүүлж байгаа Газрын тосны дамжуулах хоолойн төсөл, мөн манай аймгийн уул уурхайн салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа Бичигт боомт чиглэлийн 110 км тусгай зориулалтын авто зам, замын байгууламж зэрэг бүтээн байгуулалтын томоохон төслүүдэд шаардагдах ТТАМ-ын карьерын зөвшөөрлийг Засгийн газрын 2014 оны 222 дугаар тогтоолоор баталсан "Авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалыг хайх, ашиглах тусгай журам"-ын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хариуцан шийдвэр гаргуулж хамтран ажиллах,

2. Сүхбаатар, Эрдэнэцагаан суманд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуй нэгжүүдийн уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн тусгай зориулалтын хатуу хучилттай авто замын маршрут, чиглэлийг нэгтгэн уялдуулж батлах саналыг ЗТХЯ-нд уламжлах,

3. ТТАМ-ын тухай хууль 2014 оноос хэрэгжиж эхэлсэн. Аймгийн Засаг даргын захирамжаар ашиглалтын тусгай зөвшөөрөл олгогдсон 2 аж ахуй нэгж байна. Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажилд шаардагдах ТТАМ-ын зөвшөөрөлтэй ашиглалтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж сумдад байхгүй байгаагаас ажил удаашрах, зогсох хүндрэлтэй асуудал байнга үүсэж байна. Аймаг орон нутгийн удирдлагуудаас холбогдох яамдад албан бичиг болон салбарын зөвлөгөөнөөр дамжуулан орон нутагт зохицуулалт, шийдвэр гаргаж өгөх саналыг удаа дараа тавьдаг. Тодорхой шийдвэр гаргаагүй байна. Иймд Засгийн газар, холбогдох яамдад улсын төсвийн хөрөнгөөр сумдад баригдах дэд бүтцийн салбарт хэрэглэх ТТАМ-ын карьерын зөвшөөрлийг Засгийн газрын тогтоолоор солбицлыг батлуулж хамтран ажиллах саналыг хүргүүлэх

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ

**СҮХБААТАР АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

DJ tower 7 давхар, 7 дугаар баг
Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг, 22000
Утас: 70518892
Цахим шуудан: suaboajg@gmail.com

2023.11.21 № 263
танай 2023.11.15 -ны № 358 -т

**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Байгаль орчин, уул уурхайн нөхөн сэргээлтийн үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж доорх саналыг хүргүүлж байна.

Хавсралт: 1. хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.НЯМХҮҮ



2223030172

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын
2023 оны 11 сарын 11 өдрийн 11 дугаар
албан бичгийн хавсралт



**БАЙГАЛЬ ОРЧИН, УУЛ УУРХАЙН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ҮР ДҮН"-Д
ХИЙСЭН ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАНД ӨГӨХ САНАЛ**

1.1.1.9 Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгагдсан сөрөг нөлөөллийг бууруулах дээрх төрлийн арга хэмжээнүүдийг тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн жилийн БОМТ-нд тусган хэрэгжүүлж буй эсэхэд “Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажлын хэсэг” хяналт тавьж ажиллах шаардлагатай гэж тусгажээ.

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тушаалаар баталсан хавсралтаар баталсан журмын 4.9. Ажлын хэсэг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр нь шалгаж, дүгнэх ажлыг 11 дүгээр сарын 30-ны дотор зохион байгуулж, зөвхөн батлагдсан төлөвлөгөөнд тусгасан ажлуудын гүйцэтгэлд үндэслэн төсөл хэрэгжүүлэгч байгууллагын төлөөллийг байлцуулан, энэхүү журмын 4 дүгээр хавсралтад заасны дагуу арга хэмжээний чиглэл тус бүрээр оноогоор тооцож, биелэлтийг нь нэгтгэн гаргаж Уг заалтын улмаас ажлын хэсгийн өгсөн санал бүрэн тусгаадахгүй байна.

1.1.2.2, 1.1.2.3, 1.1.2.4, хууль журмууд нь хоорондоо зөрчилтэй байдаг.

1.2.1.1 аймгийн БОАЖГ гэдгийг хасах Ашигт малтмалын тухай хуулийн 12.2.5 ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг сумын засаг дарга хянах үүрэгтэй. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тушаалын 1 дүгээр хавсралтын /б/ загварт сумын БОХУБ хянаж, сумын Засаг дарга батална.

Б.1.1 Зарим дүйцүүлэх арга хэмжээ болон модны тарилт хангалтгүй гэжээ. Эдгээр арга хэмжээг БОМТ -ний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах чиглэлийг төрийн захиргааны төв байгууллагаас давхардуулан өгөх мөн Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 тушаалаар баталсан хавсралтаар баталсан журмын 2.7 үйл ажиллагаа явуулаагүй талаарх тодорхойлолтыг өгдөг зэргээс шалтгаалан үүсэж байна.

2.1.1.5 дүн зөрүүтэй.

Б.2.2.1.4 2018 онд хийгдсэн эвдэрсэн газрын тооллогоор эвдрэлд оруулан орхиж явсан аж ахуй нэгжүүдийг шалгуулхаар хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн.

Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:

Аймгийн Засаг даргаас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

Тайлбар 1	3.2.2.1-тэй холбоотой саналыг хүлээн авч өөрчлөлт оруулсан.
Тайлбар 2	Зөвлөмжийн төсөлд өгсөн 3 саналыг тайланд тусгах боломжгүй байна.

Аймгийн БОАЖГ-аас ирүүлсэн саналд дараах тайлбарыг өгч байна. Үүнд:

Тайлбар 1	1.1.1.9-тэй холбоотой саналыг хүлээн авч өөрчлөлт оруулсан.
Тайлбар 2	1.1.2.2-1.1.2.4-тэй холбоотой тайлбар ирүүлсэн тул хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 3	1.2.1.1-тэй холбоотой саналыг хүлээн авч өөрчлөлт оруулсан.
Тайлбар 4	Б.1.1-тэй холбоотой тайлбар ирүүлсэн тул хүлээн авах боломжгүй.
Тайлбар 5	Нотлох баримтаар дэмжигдсэн тул 2.1.1.5-тай холбоотой асуудлыг хүлээн авах боломжгүй.
Тайлбар 6	2.2.1.4-тэй холбоотой саналыг хүлээн авч өөрчлөлт оруулсан.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийлээ.

- Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгчийн ТЭЗҮ нь ордын нөөцийг бүрэн ашиглах, хатуу хучилттай авто замаар гадаад тээвэр хийх шаардлагад нийцэхгүй улмаас байгаль орчныг хамгаалах үүргийн хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж байна.
- Хаалтын менежментийн урьдчилсан төлөвлөгөөнд явцын буюу жил бүр хийх нөхөн сэргээлтийн ажлын тоо хэмжээ, зардлын дүнг тодорхой тусгадаггүйн улмаас явцын нөхөн сэргээлт хийгдэхгүй орхигдож байна.
- Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан боловч орон нутагт хүлээлгэж өгөөгүй эвдрэлд орсон талбайд байгаль орчны хохирлын үнэлгээ хийлгэж, нөхөн сэргээлтийн ажил хийлгэх шаардлагатай байна.
- Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн үйл ажиллагаанд тавих хяналт хангалтгүй байна.
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн жилд борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, улсын болон орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, төлбөрийн хэмжээг хуульд заасан хугацаанд багтаан нийтэд мэдээлээгүй байна.
- Нөхөн сэргээлтийн нөөц сан байгуулж бүртгэлд тусгаагүй тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг баталгаажуулан

хүлээн авч НББОУС-37 болон хайгуул ба олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдөж ажиллаагүй байна.

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагаас Аймаг, сумын Засаг даргатай байгуулсан гэрээнд тусгасан мөнгөн хөрөнгөнөөс гадна хууль зөрчин хандив тусламж авсан байна.
- Сангийн яам орон нутагт орох орлогыг төвлөрүүлээгүй, уул уурхайн бүтээгдэхүүнийг Монголын хөрөнгийн биржээр арилжаалах шаардлагатай байна.
- Үйл ажиллагаа явуулж байгаа орон нутагт бүртгэлгүй 17 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагын 5 нь 2022 онд 141.7 сая төгрөгийг орлогын албан татвар төлсөн. Дээрх аж ахуйн нэгж байгууллагуудыг орон нутагт бүртгэвэл төсөвт 56.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээр байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитаар өгсөн дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Аймгийн ИТХ-д:

1. Аймгийн ИТХ нь Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 3.3 заалт, Засгийн газрын 2014 оны 222 тогтоолын хавсралтын 3.4.2 дахь заалтын дагуу авто зам, төмөр замын салбарт хэрэгжүүлэх зарим төсөл, хөтөлбөрт шаардагдах түгээмэл тархацтай ашигт малтмалын борлуулалтын үнэлгээг тогтоох.

Аймгийн Засаг даргад:

1. Хүрэн нүүрс, хайлуур жонш, төмрийн хүдэр зэрэг уул уурхайн бүтээгдэхүүнийг Монголын хөрөнгийн биржээр арилжаалах талаар уул уурхайн компаниудтай байгуулдаг гурван талт гэрээнд тусгах асуудлыг харилцан санал солилцож, үр дүнд хүрэх.
2. Олон давна ХХК, Бага-Өлгий ХХК, Сэвүүн уудам тал ХХК нь БОНБУ-гүй, орд газрыг ашиглах уулын ажлын төлөвлөгөөгүй, уурхайг хүлээн авсан улсын комиссын шийдвэргүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгүй, байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлөөс өөр бичиг баримтгүйгээр үйл ажиллагаа явуулж байгаад анхаарч хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллах.

Байгаль орчин, аялал жуулчлалын газарт:

1. Тусгай зөвшөөрлийн хугацаа дуусмагц, нөхөн сэргээлт хийж, орон нутагт хүлээлгэн өгөлгүйгээр орхиж явсан тохиолдолд байгаль орчинд учруулсан хохирлыг хэмжээг тухай бүр тогтоолгож, нөхөн сэргээлтийг хийлгэх, эсхүл хууль хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулж, байгаль орчинд учруулсан хохирлыг арилгуулах.
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд тусгасан сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүдийг тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн жилийн БОМТ-нд тусган хэрэгжүүлж буй эсэхэд дүн шинжилгээ хийж, дараа жилийн БОМТ-нд тусгуулах саналыг Байгаль орчин, аялал, жуулчлалын яаманд жил бүр хүргүүлж ажиллах.
3. БОАЖГ болон сумын байгаль орчны байцаагч, мэргэжилтнүүд хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн тухайн жилийн батлагдсан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайлангийн 1 хувийг өөрийн байгууллагад тухай бүр авч хадгаламжийн нэгж үүсгэж байх.
4. Хайгуулын төслийн тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг хянаж, баталсан албан хаагч нар тухайн жилийн “Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлт”-ийг батлагдсан маягтаар жил бүр дүгнэх ажлыг зохион байгуулах.

Үндэсний аудитын газраар уламжлуулан холбогдох төр захиргааны төв байгууллагуудад хүргүүлж буй зөвлөмж:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яаманд:

1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ТЭЗҮ нь Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.5-д заасан “ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглах”, мөн хуулийн 27.1.12-т заасан “уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, дэд бүтцийг хэрхэн бүрдүүлэх талаар тодорхой тусгасан байх” шаардлагуудыг хангаж байгаа эсэхэд хяналт тавих.

Байгаль орчин, аялал, жуулчлалын яаманд:

1. Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, биелэлтийн тайланг цахим системээр иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлж байх зохицуулалтыг “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-д тусгах.
2. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид байгалийн баялгийг зохистой ашиглах, ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглах шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавих ажлыг зохион байгуулах.

Зам, тээврийн хөгжлийн яаманд:

1. Уул уурхайн бүтээгдэхүүний тээврийг тусгай зориулалтын авто замаар гүйцэтгүүлэх стандартын шаардлагыг /MNS 6278:2011/ хангуулж, “Тусгай зориулалтын авто зам, замын байгууламж барих, ашиглах журам”-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

Сангийн яаманд:

1. Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид “Хайгуул болон олборлох үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийн стандарт”-ын 4.5.2.1-д заасан “Уурхайн хаалт ба нөхөн сэргээлтэд зориулан нөөц сан”-г байгуулсан эсэхэд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 17.1.3, 17.1.7-д заасны дагуу хяналт тавьж, стандартыг мөрдүүлэх.

---oOo---